

БОДИТОЙ ИЛ ТОД БАЙДАЛ

“Орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын загвар стандарт”

Жил ирэх тусам асар ихээр нэмэгдэж буй Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний бараг тэн хагасыг эзэлдэг төсвийн төлөвлөлт ба зарцуулалтыг зөв бодлого, хяналттай байлгахын тулд хамгийн түрүүнд оролцоо, ил тод байдал хэрэгтэйг өнөөдөр жирийн иргэдээс эхлээд шийдвэр гаргагчид бүгдээрээ хэлж байна. Оролцохын тулд мэдэх хэрэгтэй. 2010-2012 онуудад дэс дараатай шинэчлэгдсэн төсвийн хууль тогтоомжинд төсвийн үйл явц болон мэдээллийг нээлттэй болгох талаар нэлээд заалт оржээ. Ялангуяа “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам” зэрэг баримт бичигт урьд өмнө байгаагүй хэдэн тодорхой зохицуулалтыг хийж өглөө. Төсвийн байгууллага мэдээллийг олон нийтэд хүргэхдээ ашиглах мэдээллийн самбарын өргөн болон урт нь 1.5 метрээс багагүй хэмжээтэй байна гэх мэтээр

заасан нь сонирхолтой. Мөн төсвийн зарим хэсгийг Орон нутгийн хөгжлийн сан нэрээр тусгаарлан нийслэл, дүүрэг, аймаг, сумдад хуваарилж хэрхэн зарцуулахыг нь тэндхийн иргэдээр баг, хорооны түвшинд хэлэлцүүлж байхаар Төсвийн тухай хууль, түүнийг дагалдуулж гаргасан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д тусгасныг 2013 оноос хэрэгжүүлж эхэлснээр ийм хэлэлцүүлгийн явцад тухайн төсвийн хэмжээ ба хуваарилалт нээлттэй болж байна.

Гэхдээ төсвийн ил тод, нээлттэй байдлыг нэгбүрчлэн авч үзвэл маш хангалтгүй хэвээр үлджээ. Яриа их болсон ч бодит ил тод байдал нэмэгдсэнгүй. Төсөвт хамаатай үйл явдлын мэдээ, тайлбар, сурталчилгаа, семинар, хэлэлцүүлэг, тэдгээрийн дотор иргэдийн оролцооны арга хэмжээ олон зохиогдсон хэдий ч ил тод байдал бодитойгоор нэмэгдээгүй гэсэн дүгнэлтийг бид хийсэн юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан

“Иргэдийн оролцоотой төсвийн менежмент” нэртэй том хэмжээний сургалтуудын үр дүн төдийлөн харагдахгүй, Орон нутгийн хөгжлийн сангаар хязгаарлагдаж байна.

ЗАГВАР СТАНДАРТ ЯАГААД ХЭРЭГТЭЙ ВЭ?

Төсвийн мэдээллийн анхдагч эх сурвалж нь төр буюу төрийн байгууллага, албан тушаалтнууд юм. Төсвийн ил тод байдал хангалтгүй байгаа нь тэд хүсэхгүй, эсвэл чадахгүй байна гэсэн үг юм. Энд хэд хэдэн шалтгаан бий.

Олон жилийн турш төсвийн үйл явц, ялангуяа төлөвлөлтийн үе шат олон нийтэд бүрэн хаалттай шахам, дээрээс нь урашигмуутай, тэр ч бүү хэл хууль зөрчсөн зарцуулалт хавтгайрч байсан нөхцөлд албан тушаалтнууд төсвийн мэдээллийг, тэр тусмаа сөрөг мэдээллийг аль болох нуун далдлах, эсвэл илэрсэн баримтыг цайруулахыг хичээж, өөрсдийгөө зөвтгөн тайлбарлаж сурчээ. Ерөөсөө энэ асуудал дээр

“ИРГЭД ТӨСВӨӨ ХЯНАНА” иргэний нийгмийн сүлжээ

аймгуудын ИТХ-аар орон нутгийн төсвийн төсөл хэлэлцэх явцад ажиглалт хийж, Засгийн газрын нөөц сангийн зарцуулалт, Улаанбаатар хотын нийтийн тээврийн хөрөнгө оруулалт, УИХ-ын гишүүдийн тойргийн мөнгө, Сэргээгдэх эрчим хүчний станцууд, төрийн албан хаагчдын орон сууцны хангамж зэрэг сэдвээр мониторинг явууллаа. Хэд хэдэн сургалт, тэдгээрийн дотор худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ сертификатын удаа дараагийн сургалтад гишүүдээ хамруулсан болно.

2011 онд Олон улсын төсвийн түншлэл байгууллагын дэмжлэгтэйгээр ННФ-аас зохион байгуулсан “Орон нутгийн төсвийн ил тод байдлын индекс” гаргах судалгаа, 2012 онд мөн Дэлхийн Банк, ННФ-ын санхүүжилт, арга зүйн дэмжлэгтэйгээр “Орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын загвар стандарт” төслийг “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээний байгууллагууд судлаачид болон төрийн байгууллагын ажилтнуудтай хамтран хэрэгжүүлсэн юм.

төр өөрөө сонирхлын зөрчилтэй учраас баталж гаргасан хууль, журмаа хэрэгжүүлж чаддаггүй.

Цаашилбал, төсвийн тасралтгүй үргэлжилдэг үйл явц ба ар араасаа урсан гарч шинэчлэгдэж байдаг мэдээллийг хүн бүрт тусгайлан хүргэж байх боломж төрд байхгүй. Нийгмийн янз бүрийн бүлэг, хувь хүмүүс, хөдөө орон нутгийн иргэдийн олон ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг яам, агентлаг, эсвэл орон нутгийн төр, захиргааны хэдэн ажилтан бүрэн судалж мэдэх, тэр тусмаа мэдээллээр тасралтгүй хангаж чадахгүй.

Ингээд төрийн зүгээс төсвийн ил тод байдлыг жинхэнэ ёсоор хангахын оронд ерөнхий тайлбар, танилцуулга, сурталчилгаа, үр ашиг муутай арга хэмжээ зэргээр орлуулж ирлээ. Хамгийн гол нь нэг талаас төрийн албан хаагчдын өгч байгаа болон нөгөө талаас иргэд, олон нийт авахыг хүсч байгаа төсвийн мэдээллийн тухай ойлголт зөрүүтэй байна. Зөрүүтэй төдийгүй нийцүүлэхийг оролддоггүй учраар төрийн зүгээс ил тод байдлыг сайн хангаснаа тайлагнаж байхтай зэрэгцэн төсвийн мэдээлэл хаалттай талаар төрийн бус байгууллагууд шүүмжилсээр өдий хүрлээ.

Бидний үзэж буйгаар, төсвийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлын шалгуур нь хувь хүн, байгууллагууд тухайн төсөв, санхүү, хөрөнгө оруулалт, худалдан авалтын үйл явц болон баримт бичгийг бүхэлд нь буюу өөрт хамаатай, эсвэл сонирхсон хэсгийг задаргаатайгаар цаасан болон цахим хэлбэр, хэвлэл мэдээллийн хэрэгслээр, тэгэхдээ аль болох бага цаг зарцуулан, зардал багатайгаар олж авч ашиглах боломжийг бүрдүүлсэн байх явдал юм.

Төр бол төсвийн мэдээллийн эх сурвалж, тэгэхдээ баталгаатай эх сурвалж байх учиртай. Заавал хүн бүрийн гарт хүргэж атгуулахгүй байж болно, гэхдээ иргэн хүн хүссэн буюу хэрэгцээ гарсан тохиолдолд бэлэн байлгах ёстой. Энэ нь “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн үндсэн хоёр зарчмын нэг буюу төрийн мэдээллийг иргэд хүссэн, хүсээгүйгээс үл хамааран “автоматаар” нээлттэй байлгах үүрэг юм. Нөгөө нь төрөөс мэдээлэл хүсэхэд тодорхой хугацаанд өгдөг байх ёстой.

Мэдээж хуулиар хориглосон бол дэлгэж болохгүй, гэхдээ тийм мэдээлэл тун цөөн, бусад нь нээлттэй байх учиртай. Гэхдээ төсөвтэй холбоотой ямар ч хамаагүй мэдээлэл гэсэн үг огт биш.

Хэн нэгэн иргэнд тухайн цаг хугацаанд төсвийн тов тодорхой мэдээлэл хэрэгтэй байдаг тул ийм мэдээллийг бэлтгээд зогсохгүй үргэлж шинэчлэн байнга бэлэн байлгах ёстой.

Үүнийг төрөөр хийлгэхийн тулд эрх зүйн зохицуулалт шаардагдана. “Хэрвээ иргэн хүн хуулиар хориглоогүй бүхнийг хийх эрхтэй бол төр зөвхөн хуулиар зөвшөөрснийг хийх үүрэгтэй” гэсэн зарчим энд үйлчилнэ. Өөрөөр хэлбэл, төрийн байгууллага, албан тушаалтнуудад хууль, журам, дүрмээр үүрэг хүлээлгэсэн тэр хэм хэмжээ, зохицуулалтын хүрээнд ажиллаж, иргэд, олон нийт зөвхөн тэр хүрээнд шаардах эрхтэй юм.

Төсвийн тухай ерөнхий бөгөөд хоосон яриа, хэрэгтэй хэрэггүй элдэв мэдээ, тайлан, тайлбар, эцэс төгсгөлгүй ухуулга сурталчилгаа хэрэггүй. Ерөнхий ярих ба тодорхой хийх хоёрын хооронд тэнгэр газар шиг ялгаа бий. Хэрвээ ил тод байдлыг нарийвчлан тодорхойлж чадвал төр, албан тушаалтнууд ил тод, нээлттэй байдлыг үнэхээр хүлээн зөвшөөрч байгаа юм бол хэрэгжүүлж харуулахаас өөр аргагүйд хүрнэ. Тухайн албан тушаалтны хувийн зан чанар, хүсэл зориг, улс төрийн нөлөө, байгууллагын эрх ашиг, сонирхлын зөрчлөөс хамаарахгүй болно. Нөгөө талдаа иргэд, олон нийт, татвар төлөгчид юуг шаардах, хянах нь тов тодорхой болно. Төсвийн ил тод байдлыг хэмжих ба үнэлж дүгнэх шалгуур гарч ирнэ.

Яваандаа төсвийн ил тод, нээлттэй байдал нь төрийн үйл ажиллагааны хэм хэмжээ, соёл болж төлөвшинэ.

Өнгөрсөн жилүүдийн төсвийн асуудлаар болсон хурал семинар, мониторингийн дүгнэлт, зөвлөмжийг судлахад, төрийн байгууллага, албан тушаалтнуудад ойлгуулж ухамсарлуулахаас эхлээд зааж сургах, нөлөөлөх, бас хамтран ажиллах шаардлагатайг дахин дахин заасан байдаг. Бүгд зөв зүйтэй санаа боловч төсвийн ил тод байдал гэж чухам юу болох, ямар мэдээллийг хэрхэн ил тод болгохыг нарийвчлан тогтоохгүй явж ирсний улмаас үр дүнд хүрдэггүй байсан гэж бид үзлээ.

Одоо хэрэгжиж буй хууль, журам, дүрмэнд төсвийн нэлээд мэдээллийг хэрхэн нээлттэй болгохоор заасныг дээр тэмдэглэсэн. Нэгэнт эрх зүйн шаардлага учраас албан тушаалтнууд мөрдөх үүрэгтэй. Харамсалтай нь тэгдэггүй байна. Учир нь, тийм заалтууд голдуу ерөнхий (жишээлбэл, бараа, ажил үйлчилгээ худалдаж авах ажиллагааны явц ба хэрэгжилтийн ил тод байдлын тухай заалтуудыг дурдаж болно), хэрэгжүүлэх дэс дараалал, процедур байхгүй, үгүй бол төсвийн нэг хэсгийг зохицуулсан мөртлөө нөгөө хэсгийг орхигдуулсан, эсвэл өөр хоорондоо зөрчилдсөн гэх мэтээр иж бүрэн зохицуулалт болж чадахгүй байна.

Яагаад чадаагүй вэ? Өнөөдөр шийдвэр гаргагчид төсвийн ил тод байдлын асуудлыг нэгмөсөн

шийдэхээр гэнэтхэн зориг шулуудлаа гэхэд чадахгүй. Яагаад гэвэл тэд мэдэхгүй. Нөгөө талаас олон нийт шууд хэлээд өгч чадахгүй. Төсвийн чухам ямар баримт бичиг, үйл явцыг хэзээ, хэрхэн ямар хэлбэрээр, хэн ил тод, нээлттэй болгох шаардлагатайг нэгбүрчлэн судалж тогтоох, тэгээд талууд хэлэлцэж зөвшилцөх багагүй цаг хугацаа шаардах ажил хийгдэж эхлээгүй байсан.

ОРОН НУТГААС ЭХЛЭХИЙН УЧИР

Хэдэн их наядаар хэмжигдэх болсон Монгол Улсын нийт төсвөөс эхлээд бүхэл бүтэн салбар, яам, агентлаг, улсын төсвийн хөрөнгө оруулалт, “Хүний хөгжил” сан, “Чингис бонд”, гадаадын зээл тусламжийн төсөв хөрөнгийн зарцуулалтыг иргэд мэдэх хэрэгтэй. Гэхдээ үүнээс өмнө ард иргэдэд ойр байдаг, тэдний өдөр тутмын ажил амьдрал шалтгаалдаг, энэ утгаараа сонирхох төдийгүй хянах, оролцох боломжтой орон нутгийн төсвөөс эхлэх нь зүйтэй.

“Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээ 2009 оноос эхлэн орон нутгийн төсвийг үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэл болгосон юм. Бид эхлээд нийслэл Улаанбаатар хот, түүний дүүргүүд болон аймгуудын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тухайн орон нутгийн төсвийн төслийг хэлэлцэн батлах үйл явцад мониторинг хийж эхэлсэн. 2011 онд Олон улсын төсвийн түншлэл байгууллагын Нээлттэй төсвийн санаачлага, Нээлттэй Нийгэм Форумын санхүүгийн болоод арга зүйн дэмжлэгтэйгээр “Иргэд төсвөө хянана” сүлжээний гишүүн ба түнш байгууллагууд хамтран “Орон нутгийн төсвийн ил тод байдлын индекс” тогтоосон юм. 2012-2013 онуудад энэхүү “Орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын загвар стандарт”-ыг боловсруулж гаргаад байна.

ЗАГВАР СТАНДАРТ ГЭЖ ЮУ ВЭ?

Стандарт гэж нэрлэсний учир бол аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн мэдээллийг ил тод хангахад дагаж мөрдөх дэлгэрэнгүй заавар байх юм. Харин бид албан ёсны стандартыг батлах эрхгүй тул загвар хэмээн нэрлэв. Бүхэлдээ судалгааны үндсэн дээр боловсруулж туршсан, орон нутгийн төр захиргаа, иргэд, судлаачдын санал бодлыг тусгасан зөвлөмжийн шинжтэй баримт бичиг байна.

Загвар стандартыг нийслэл Улаанбаатар хот, түүний Баянзүрх дүүрэг, Ховд аймаг ба түүний Дөргөн сумын хэмжээнд туршин хэрэгжүүлж аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлагын нэгж, тэндхийн төр

захиргаа, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээд буюу орон нутгийн өмчит болон түүний оролцоотой аж ахуйн нэгж, төрийн чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэдэг болон төсвөөс санхүүжилт авдаг орон нутгийн бусад байгууллагуудын захиран зарцуулдаг төсвийг нээлттэй болгоход ашиглана.

Загвар стандартыг авч хэрэгжүүлэх эсэх нь сайн дурын үндсэн хэрэг боловч Монгол улсын төсвийн холбогдолтой хууль тогтоомжийн заалтуудад бүрэн нийцсэн тул дагаж мөрдөх, хэрэгжүүлэхийг иргэд, олон нийт, татвар төлөгчдийн зүгээс шаардах, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах үндэс болж чадна.

Нутгийн өөрөө удирдах ёсны зарчмын дагуу аймаг, нийслэл, дүүрэг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, эсвэл Засаг даргын зүгээс тухайн нутаг дэвсгэрт заавал биелүүлэх эрх зүйн баримт бичиг шийдвэрийг гаргах эрхтэй учраас загвар стандартыг нийтэд нь, эсвэл төсвийн мэдээллийн цахим сайт ба буланг хүлээн зөвшөөрч албажуулсан тогтоол, захирамж гарган ашиглах, эсвэл төстэй баримт бичиг болон үйл ажиллагааны үндэс суурь байж чадна. Загвар стандартыг иж бүрнээр, эсвэл хэсэгчлэн хэрэгжүүлж болохоос гадна түүнд тулгуурласан илүү нарийвчилсан шаардлага, агуулга бүхий дараачийн загварыг боловсруулах, цаашдаа төсвийн хууль тогтоомж, нэр томъёо, баримт бичиг, үйл явцад өөрчлөлт гарвал түүнд тохируулан өөрчлөх боломжтой.

Загвар стандартыг боловсруулсан үйл явцыг товч дурдахад эхлээд “Орон нутгийн төсвийн үйл явц, баримт бичгүүдийн ил тод, нээлттэй байдлын хууль, эрх зүйн шаардлагуудын нэгдсэн зураглал (mapping) гаргасан юм. Үүгээр “Төсвийн тухай хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”, “Хандив тусламжийг бүртгэх журам”, “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” зэрэг хууль, Засгийн газрын тогтоол, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (Санхүү, эдийн засгийн яам, Сангийн яам)-ын сайдын тушаалаар батлагдсан журам, дүрэм, тэдгээрийн хавсралтад заасан орон нутгийн төсвийн баримт бичиг ба үйл явцын ил тод, нээлттэй байдлын эрх зүйн шаардлагуудыг нэгбүрчлэн судалж боловсруулан цаглабар хэлбэрээр нэгтгэн харуулсан.

Гэхдээ зөвхөн энэ биш. Орон нутгийн төсвийн зарим баримт бичиг ба үйл явцыг дэлгэн харуулах

эрх зүйн шаардлагууд байхгүй, эсвэл хэт ерөнхий, процедур орхигдсон зэрэг тохиолдолд тийм “цоорхой”-г нөхөж гүйцээсэн болно.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН 37 ЗАГВАР ГАРГАВ

Загвар стандартын цөм нь орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын загварууд юм. Аймаг, нийслэл, сум, дүүрэг ба төсвийн байгууллагын төсвийн жилийн турш ил тод, нээлттэй болгох шаардлагатай цаглабар, баримт бичиг, үйл явц, тэдгээрт холбогдох хууль, дүрэм, журмын заалтууд (төсвийн баримт бичгийн нэр, ил тод болгох хугацаа, арга хэлбэр), төсвийн баримт бичиг, мэдээллийн агуулга, бүтэц, задаргаа, нарийвчлал (хууль, журманд заасан болон төслийн зүгээс санал болгож байгаа), төсвийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах арга, хэлбэр буюу загвар (хууль, журманд заасан болон төслийн зүгээс санал болгож байгаа)-ыг эндээс харж ашиглана. Ингэхдээ товчхон, цэгцтэй байх зарчмыг баримталж ижил төстэйг нэгтгэн дэлгэрэнгүй тайлбарыг нэгдсэн зураглалаас авч ашиглахаар бэлтгэв.

2013 оны 3-р сарын байдлаар бэлэн болсон 37 загвар байна. Үүнээс 36 нь үгээр тайлбарласан, нэг нь хүснэгт болно. Хууль тогтоомжийн өөрчлөлтөөс шалтгаалан загваруудад өөрчлөлт орох буюу тоо нь нэмэгдэж хасагдаж болно.

Жишээ болгож зарим загварыг дор тайлбарлав.

Орон нутгийн төсвийн хамгийн чухал хэсэг нь хөрөнгө оруулалт буюу худалдан авалт байдаг. Заавал орон нутгийн төсвийнх байх албагүй ба тухайн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа улсын төсөв, гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалт ч хамаарна. Энэ бүх худалдан авалтын үр шимийг нутгийн иргэд хүртэх учраас төлөвлөлт, явц, үр дүнг эхнээс нь дуустал мэдэж байх явдал маш чухал. Гэтэл жилийн эхэнд худалдан авалтын жагсаалтыг нийтэлж, дараа

нь тендерийн урилгыг нийтэлснээр хязгаарлаж үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, ямар компаниуд тендерт оролцож хэн нь яагаад шалгарсан, байгуулсан гэрээ, ажлын эхэлж дуусах хугацаа гэх мэт мэдээлэл хаалттай өнгөрдөг. “Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-д үүнийг “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-иар зохицуулна гэж заасан байдаг ч тэнд орсон заалтууд бас л ерөнхий учраас ил тод байдал нэг ёсондоо “завсардаж” хэрэгжихгүй байна. Бид энэ бүгдийг харгалзаад худалдан авалтын мэдээллийн хүснэгтийг боловсруулж гаргасан юм. Хэрвээ захиалагчид энэ хүснэгтийг дэс дараатай бөглөөд явбал тухайн худалдан авалтын ил тод байдал хангагдана гэж үзлээ.

1	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр, товч тодорхойлолт	
2	Худалдан авалтын хэлбэр (нээлттэй тендер, харьцуулалтын арга, шууд гэрээ байгуулах, зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох)	
3	Төсөвт өртөг	
4	Хөрөнгө оруулалтын төрөл (улсын төсөв, орон нутгийн төсөв, эрх шилжиж ирсэн г.м.)	
5	Худалдан авах ажиллагааны төрөл (бараа, ажил, зөвлөх үйлчилгээ, зөвлөхөөс бусад үйлчилгээ)	
6	Урилга ба үнийн санал (ОНМХ-ээр зарласан буюу хүргүүлсэн байдал, давтамж, огноо г.м.) Урилгыг хавсаргана.	
7	Үнэлгээний хороо (Бүрэлдэхүүн, дарга, гишүүдийн нэрс, албан тушаал, ТББ-ын төлөөлөл орсон эсэх г.м.)	
8	Үнэлгээний хороо ажилласан байдал (тендерийн ямар баримт бичиг, материал бэлтгэсэн, хэзээ яаж хуралдсан, тендерийн үе шатууд, гэрээ байгуулах эрх олгосон дүгнэлт зөвлөмж гаргасан огноо дугаар г.м.)	
9	Тендерийн нээлт (Огноо, нээлттэй байдал г.м.)	
10	Тендерт оролцогчдын тоо, нэрсийн жагсаалт	
11	Шалгарсан компани, байгууллага (Товч танилцуулга, бүртгэл, удирдах албан тушаалтан, хаяг г.м.)	
12	Гомдол гарсан эсэх, хэрвээ тийм бол хэн гаргасан, гомдлын агуулга, хэрхэн шийдэгдсэн	
13	Худалдан авах гэрээ байгуулсан (огноо, дугаар г.м.)	
14	Гэрээнд зааснаар, хэрэгжиж эхлэх ба дуусах хугацаа	
15	Хэрэгжиж эхэлсэн огноо	
16	Хэрэгжилтийн явц: ... сарын ... –ны байдлаар	
17	Хэрэгжилтийн явц: ... сарын ... –ны байдлаар	
18	Хэрэгжилтийн явц: ... сарын ... –ны байдлаар	
19	Хэрэгжиж дууссан буюу худалдан авах гэрээг дүгнэж бараа, ажил үйлчилгээг хүлээж авсан огноо, баримт бичгийн дугаар	
20	Худалдан авалтын чанар, үр дүнгийн талаархи мэдээлэл, дүгнэлт	

Худалдан авалтын явцыг олон нийтэд хэрхэн хүргэх тухай яв цав заалт хууль, журманд байхгүй. Гэтэл төсвийн ерөнхийлөн захирагч нар ийм тайланг сар тутам гаргаж Сангийн яаманд хүргүүлж байх тухай заалт нэгэн журманд байсныг үндэслэн дараах загварыг гаргасан юм. Дээш тайлагнаж болдог мэдээллийг ард иргэдээс нуух шалтгаан байхгүй гэж үзлээ.

ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОЛГОХ:

Хөрөнгө оруулалт, худалдан авалтын явц, үр дүнгийн сарын мэдээ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТ:

3.29.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь тухайн орон нутагт төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд мэдээлэх ажлыг тогтмол гүйцэтгэх бөгөөд санхүүжилт хийгдсэн тухай бүр мэдээллийг шинэчилж байна.

4.5.Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй ажлын санхүүжилт, түүний гүйцэтгэлтэй холбоотой

асуудлаар төсвийн эрх захирагч, тухайн нутгийн захиргааны байгууллагаас орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагуудыг хөндлөнгийн хяналт тавих боломжоор хангах үүрэгтэй.

6.3.Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг сар бүр энэ журмын тавдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж, сар бүрийн дараа сарын 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ.

(“Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”. Сангийн сайдын 2012.12.27-ны 290-р тушаалаар батлагдсан)

ХУГАЦАА:

Сар бүрийн 5-ны дотор буюу Сангийн яаманд хүргүүлэхтэй нэгэн зэрэг

АРГА ХЭЛБЭР БУЮУ ЗАГВАР:

Сангийн сайдын 2012.12.27-ны 290-р тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын Хавсралт №5 буюу “..... Аймаг/сумын нутагт улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилгын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн-р сарын мэдээ” маягтын дагуу.

Урьд нь дараа жилийн төсвийн төслийг ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж баталсан тогтоолыг нийтлээд ил тод болгосонд тооцдог нь хангалтгүй байсныг аймаг, нийслэлийн төсвийн батлагдсан төсвийн дараах загвараас харж болно.

ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОЛГОХ:

Аймаг, нийслэлийн ирэх оны батлагдсан төсөв

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТ:

4.2. Тухайн жилийн төсвийг эрх бүхий байгууллагаас баталж, хүчин төгөлдөр болсны дараа төсвийн захирагч дор дурдсан хугацаанд олон нийтэд мэдээлнэ:

4.2.2. төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн багцын төсвийг 7 хоногийн дотор олон нийтэд мэдээлнэ.

(“Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”)

68.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ.

(“Төсвийн тухай хууль”)

ХУГАЦАА:

12-р сарын 12-ны дотор

АРГА ХЭЛБЭР БҮЮУ ЗАГВАР

Батлагдсан төсөв бүрэн эхээрээ, хавсралтуудын хамт. Үүнд:

Нэг.

1.Төсөв батлах тухай тогтоол

2.Төсвийн төлөвлөгөө (орлого зарлагын төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө)

3. Хавсралтууд

Хоёр.

68.1. Орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална.

33.2. Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална:

33.2.1. төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого;

33.2.2. төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн зарлагын дээд хэмжээ, урсгал болон хөрөнгийн зарлагын дээд хэмжээ, үүнээс тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ;

33.2.3. төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, Засгийн газрын шинээр үүсгэх өр, гаргах баталгааны дээд хязгаар, мөнгөн гүйлгээтэй холбогдох хязгаарлалт;

33.2.4. бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг;

33.2.5. төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар;

33.2.6. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;

33.2.7. концессын гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт, тэдгээрт тавигдах тусгай шаардлага, нөхцөлийг хавсралтаар.

68.2. Төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана.

(“Төсвийн тухай хууль”)

Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг нэг ч Засаг дарга Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн барихаасаа өмнө олон нийтэд танилцуулж байгаагүй юм. Тэр ч бүү хэл Иргэдийн хурлын төлөөлөгчид хүртэл өөрсдөө “төсвийн төслийг бидэнд ганц нэгхэн хоногийн өмнө өгдөг, сайн судалж амжихгүй байна” гэсэн гомдол мэдүүлдэг. Тэгвэл Төсвийн тухай хуулинд төсвийн төслийг боловсруулах явцдаа олон нийтэд танилцуулах заалт орсныг бид дараах загварт тусгаж хамаарах баримт бичгүүдийн жагсаалт, задаргааг багтаалаа.

ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОЛГОХ:

Аймаг, нийслэлийн ирэх оны төсвийн төсөл (ИТХ-д өргөн мэдүүлсэн)

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТ:

8.5.1. аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх; 67 дугаар зүйл.Орон нутгийн төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх

67.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

67.3.Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг

иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

(“Төсвийн тухай хууль”)

7.4.Аймаг, нийслэлийн аудитор жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ.

(“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”)

ХУГАЦАА:

11-р сарын 25-ны дотор.

АРГА ХЭЛБЭР БҮЮУ ЗАГВАР

67.2. Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгад энэ хуулийн 32.2.1-32.2.12, 32.2.19, 32.2.20-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

67.2.1. орон нутгийн төсвийн бодлогын зорилтыг тусгасан дунд хугацааны төлөвлөгөө;

67.2.2. энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан төсвийн ангиллын дагуу боловсруулсан төсвийн төслийн

тооцоо, танилцуулга;

67.2.3. аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгохоор төлөвлөсөн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн санал;

67.2.4. дээд шатны төсөвт тусган баталсан дээд шатны төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ.

(“Төсвийн тухай хууль”)

7.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн төсвийн төслийг энэ журмын 5.1-д заасан мэдээлэлд үндэслэн Төсвийн тухай хуулийн 33.2-т заасны дагуу боловсруулж, мөн хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.

7.5. Аймаг, нийслэлийн жилийн төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 33.2-т заасныг дор дурдсан байдлаар тусгана: [Цааш задалж нэгбүрчлэн тайлбарласан болно]

(“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”)

2012 оны 11-р сарын 19-нд Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-д Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөөг иргэдээр хэлэлцүүлэхээр заасныг үе шат бүрээр задалж цаглабарын хэлбэрт оруулсныг дараачийн загвараас харж болно.

ИЛ ТОД, НЭЭЛТЭЙ БОЛГОХ:

Ирэх онд сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар санал асуулга явуулж, жагсаалт боловсруулан өргөн барих үйл явц, үр дүн.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТ:

12.2.1.баг, хорооны Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг явуулна:
12.2.1.6/ саналыг асуулгын хуудсаар авахад энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягыг ашиглах ба маягтыг баг, хорооны айл өрх бүрт жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ; [Энэ нь 3-р сарын 31-ны дотор гэсэн үг юм]
12.2.1.в/энэ журмын 12.2.1.а-т заасан хэлбэрээр санал асуулгыг явуулахдаа, жил бүрийн 2 дугаар улирлын эхний 30 өдөрт багтаан санал авна. [Энэ нь 4-р сарын 30-ны дотор гэсэн үг юм]
12.2.3.баг, хорооны Засаг дарга иргэдийн Нийтийн Хурал хуралдахаас 2 долоо хоногийн өмнө тухайн сум, дүүрэгт хуваарилагдах хөрөнгийн урьдчилсан тооцоо, иргэдээс гаргасан саналын урьдчилсан жагсаалт, сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн тухайн сум, дүүрэг, баг хороонд хэрэгжүүлэх шаардлагатай хөгжлийн бодлого чиглэлтэй уялдсан төслүүдийн мэдээлэл,

өмнөх жилүүдэд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх товч мэдээллийг баг, хороодод байршуулсан байна; [Энэ нь 6-р сарын 15-наас өмнө гэсэн үг юм]

12.2.4.баг, хорооны Засаг дарга иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдсан төслийн санал болон иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг тухайн иргэдийн Нийтийн Хуралд хэлэлцүүлж, тус хурлаас эрэмбэлэгдэн гарсан төслийн жагсаалтыг сум, дүүргийн Засаг даргад 2 дугаар улиралд багтаан хүргүүлнэ; [Энэ нь 6-р сарын 30-ны дотор гэсэн үг юм]
12.2.5.сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхийн санал авсан дарааллаар нь эрэмбэлж багцлана:
12.2.5.6/ сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн төслийн саналын төсвийн нөлөөллийн тооцоог боловсруулж хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг 60 өдөрт нэгтгэн боловсруулна. [Энэ нь 8-р сарын 30-ны дотор гэсэн үг юм]
12.2.6.сум, дүүргийн Засаг дарга олон нийтээс авсан саналын дагуу хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг олон нийтэд танилцуулан, нээлтэй хэлэлцүүлэг зохион байгуулж болно;

12.2.7.сум, дүүргийн Засаг дарга эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй

уялдсан, энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гаргаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ [Энэ нь төсвийн тухай хуулиар, 12-р сарын 10-ны дотор гэсэн үг];

12.2.8.сум, дүүргийн Засаг дарга баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас баталгаажсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй бол саналын жагсаалтыг тусад нь бэлтгэж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж төсвийн төсөл боловсруулах журам) (Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам)

ХУГАЦАА:

03.31-ны дотор ба түүнээс хойш (Дээр тодорхой тэмдэглэсэн хугацааны үе шатуудыг хамаарна)

АРГА ХЭЛБЭР БУЮУ ЗАГВАР:

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын (Сангийн сайдын 2012.11.19-ны 244-р тушаалаар баталсан) хавсралтад заасан дараах загвар, маягтуудын дагуу ил тод болгоно. Үүнд:

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 1-р хавсралтад заасан “Орон нутгийн хөгжлийн сан. Иргэдээс санал авах маягт” байна.

2-р хавсралт. Баг/хорооны Иргэдийн нийтийн хурлын тэмдэглэл (Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээг хэлэлцэхэд ашиглах маягт)

3-р хавсралт. Орон нутгийн хөгжлийн сан. Хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тодорхойлох маягт.

Сүүлийн жилүүдэд маш их шүүмжлэл хүлээж байгаа жижиг дунд үйлдвэрийн зээлийг багтаадаг сум хөгжүүлэх сангийн ил тод байдлын загвар энд байна.

ИЛ ТОД, НЭЭЛТЭЙ БОЛГОХ:

Сум хөгжүүлэх сангийн улирлын тайлан.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТ:

5.1.Сангийн үйл ажиллагааг нийтэд ил тод явуулна. Сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад тухайн сумын иргэд хяналт тавих эрхтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт шалгалт хийлгэж болно.
5.3.Энэхүү журмын 3.1.5-д заасан ажлын хэсэг сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэд тухайн санхүүгийн жилд 2-оос доошгүй удаа шалгалт хийж, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлж байна.
5.4.Сумын Засаг дарга сум хөгжүүлэх сангийн орлого,

зарлагын дүн болон зарцуулалтын тайланг улирал, жилээр гаргаж, улирлын эхний сарын 10-ны дотор аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газарт хүргүүлнэ. Аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар сумдын тайланг аймгийн хэмжээнд нэгтгэж, улирлын эхний сарын 20-ны дотор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам тайланг улсын хэмжээнд нэгтгэж улирлын эхний сарын 30-ны дотор Сангийн яаманд тус тус хүргүүлнэ.
5.5.Жил бүрийн сум хөгжүүлэх сангийн гүйцэтгэл, үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийлгэж, аудитын дүгнэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх, нэгдсэн дүнг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Сангийн яаманд ирүүлэх асуудлыг аймгийн хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газар хариуцаж ажиллана.

(“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам” (Засгийн газрын 2011.04.27-ны 134-р тогтоолоор батлагдсан)

ХУГАЦАА:

Улирал бүрийн дараа сарын 10-ны дотор

АРГА ХЭЛБЭР БУЮУ ЗАГВАР

1.Сум хөгжүүлэх сангийн улирлын тайлан
2.Сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэд хийсэн шалгалтын дүн (тухайн улиралд гарсан тохиолдолд)
3.Жил бүрийн сум хөгжүүлэх сангийн гүйцэтгэл, үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн аудитын дүн (тухайн улиралд гарсан тохиолдолд)

Тухайн жилийн батлагдсан төсөв гэхлээр хэдхэн тоо жагсаадаг буруу зуршил тогтжээ. Үнэн хэрэгтээ маш олон баримт бичиг байх ёстойг дараах загвараас харж, бас нэхэж болно.

ИЛ ТОД, НЭЭЛТЭЙ БОЛГОХ:

Тухайн жилийн батлагдсан төсөв

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТ:

Нэг.
4.2.1.тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг өөрийн цахим хуудас болон Монгол Улсын төсвийн ил тод байдал цахим хуудсанд дор дурдсан хугацаанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх:
9.1.1.а.тухайн жилийн төсвийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор; (“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”)

Хоёр.

“4.2. Тухайн жилийн төсвийг эрх бүхий байгууллагаас баталж, хүчин төгөлдөр болсны дараа төсвийн захирагч дор дурдсан хугацаанд олон нийтэд мэдээлнэ:
4.2.2. төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн багцын төсвийг 7 хоногийн дотор олон нийтэд мэдээлнэ” гэж заажээ.

(“Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”)

ХУГАЦАА:

01-р сарын 10-ны дотор

АРГА ХЭЛБЭР БУЮУ ЗАГВАР:

Нэг.
Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийг батлагдсан бүрэн эхээр нь ил тод болгоно. Энэ нь “Орон нутгийн

төсвийн төсөл боловсруулах журам”-ын хавсралт загвар, маягтуудын дагуу батлагдсан баримт бичгүүд байх юм.

Үүнд:

1. Хавсралт №2аймаг/нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоол. Загвар маягт. “ ... аймаг/нийслэлийн оны төсөв батлах тухай.

Мөн тус тогтоолын хавсралтанд заасан загвар, маягтуудын дагуу батлагдсан бусад баримт бичгүүд байна.

Үүнд:

2. “Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн” (... аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 1 дүгээр хавсралт),

3. “...аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт (... аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 2 дугаар хавсралт),

4.“...аймаг/нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт” (... аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 3 дугаар хавсралт),

5.“...сум/дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны тогтоол (загвар маягт) “.... сум/дүүргийн оны төсөв батлах тухай”,

6.“Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн” (...сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 1 дүгээр хавсралт)

7.“...сум/дүүргийн төсвөөс санхүүжих хөрөнгө

оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт (... сум/дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 2 дугаар хавсралт),
8.“...сум/дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт” (... сум/дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 3 дугаар хавсралт),

Хоёр.

Гурав. Мэдээллийн бүтэц

3.1. Төсвийн байгууллагын мэдээлэл дараахь бүтэцтэй байна:

3.1.1. эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв;

3.2. Энэ журмын 3.1.1-д заасан мэдээлэл дараахь байдлаар илэрхийлэгдсэн байна:

3.2.1. эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт;

3.2.2. орлого (үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого);

3.2.3. урсгал зардал (үндсэн цалин, цалингийн нэмэгдэл, бараа үйлчилгээний зардал, татаас, шилжүүлэг);

3.2.4. хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессийн зүйлсийн жагсаалт;

3.2.5. улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа;

3.2.6. зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр (улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлого);

3.2.7. байгууллагын батлагдсан орон тоо.

(“Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”)

Орон нутагт хамгийн хаалттай мэдээллийн нэг бол Засаг даргын нөөц хөрөнгө юм. Түүнийг ил тод болгох заалт төсвийн болон бусад хууль тогтоомжоос олдоогүй. Гэхдээ тус сангийн журмаар бол зарцуулалт, үлдэгдлийг нь Засаг даргын зөвлөлийн хуралд улирал тутам танилцуулж байх ёстой ажээ. Үүнийг иргэддээ танилцуулж байхад ямар ч саадгүй юм. Иргэд үүнийг мэдэх эрхтэй.

ИЛ ТОД, НЭЭЛТЭЙ БОЛГОХ:

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын улирлын тайлан

улирал бүр танилцуулж байна". ("Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам". Сангийн сайдын 2012.11.15-ны 239 тоот тушаалаар батлагдсан)

АРГА ХЭЛБЭР БУЮУ ЗАГВАР:

Засаг даргын зөвлөлийн хуралд хийсэн танилцуулгыг бүрэн эхээр нь буюу задаргаатай жагсаалт хэлбэрээр. Өмнөх оны 4-р улирлын тайлан нь жилийн тайлан байна.

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЗААЛТ:

"Тухайн шатны Засаг даргын тамгын газрын Санхүү, төсвийн асуудал хариуцсан хэлтэс (тасаг) Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, эх үүсвэрийн үлдэгдлийн талаархи мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хуралд

ХУГАЦАА:

Улирал тутмын дараа сарын 20-ны дотор (барагцаалбал)

Нийт 37 загварын зарим нь зөвхөн аймаг, нийслэл, зарим нь зөвхөн сум, дүүрэг, зарим нь зөвхөн төсвийн байгууллагад, гэхдээ ихэнх нь төсвийн хэд хэдэн субъектэд зэрэг хамаарч байгаа юм.

ТӨСВИЙН МЭДЭЭЛЭЛ ХААНА БАЙХ ЁСТОЙ ВЭ?

Орон нутгийн төсвийн мэдээллийн бүтэц, агуулгыг дээрх Загвар стандартаар тодорхой болгосны дараа олон нийтэд хүргэх хамгийн оновчтой бөгөөд үр дүнтэй хоёр арга замыг боловсруулав. Нэг нь төсвийн цахим сайт, нөгөө нь номын сан дахь төсвийн мэдээллийн булан юм. Нэг нь Интернэтийн виртуал, нөгөө нь бодит орон зайд байрлана.

ӨНӨӨДӨР ТӨСӨВ, САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЗӨВХӨН ЦАХИМ САЙТАД БАГТААЖ, ТАСРАЛТГҮЙ ШИНЭЧИЛЖ, БАС ТҮГЭЭЖ ЧАДНА

Төсөв бол жилийн турш урьд оны гүйцэтгэлийг тайлагнаж, тухайн жилийн төсвийг хэрэгжүүлж, ирэх жилийн төсвийн төслийг боловсруулж байдаг гурван зэрэг үйл явц юм. Ийм их мэдээллийг тасралтгүй ил тод болгож байх боломжийг зөвхөн цахим сайт олгоно.

Иргэд тус тусын аймаг, нийслэл, сум, дүүргээс эхлээд өөрсдийн ажил, амьдралд хамаатай байгууллагуудын гэхчлэн хэд хэдэн төсвийн мэдээллийг авч байх, үүний тулд төрийн байгууллагууд худалдан авалтын үйл явцыг оруулаад зарим сард 10 хүртэл баримт бичгийг нээлттэй болгох шаардлагатай. Цахим сайтаас өөр боломж байхгүй. Тогтсон огноогүй, байнга үргэлжилдэг хэрнээ зарлах, үнэлэх, дүгнэх үе шатууд нь цаг хугацааны хатуу интервалтай худалдан авалтын үйл явцыг нээлттэй болгох хамгийн шуурхай арга бол бас л цахим сайт.

Цахим сайт бол төсвийн мэдээллийн нэг цэгийн үйлчилгээ байна.

Хот суурин газрын захын хорооллын оршин суугчид, ялангуяа хөдөөний малчид, нийгмийн

эмзэг давхаргын хүмүүст Интернэт хүртээмжгүй нь үнэн боловч төрийн албан хаагчид, төрийн бус байгууллага, бизнес эрхлэгчид, оюутан сурагчид зэрэг нийгмийн идэвхтэй хэсэгт хүртээмжтэй учраас тэднээр дамжуулан төсвийн мэдээллийг бүх нийтэд хүргэх боломж нээгдэж байна.

Цахим хуудсыг онцолсноороо төсвийн мэдээллийг нээлттэй болгох бусад арга хэлбэрийг огт үгүйсгээгүй бөгөөд харин ч цахим хуудас хэмээх нэг цэгт шуурхай, хүртээмжтэй, цэгцтэй байрлуулж хуримтлуулан тасралтгүй шинэчлэх ба тэр хэлбэрээр болон өөр бусад хэлбэрт чөлөөтэй хувирган ашиглаж, дамжуулж, түгээж чадна.

Одоохондоо төсвийн болон төрийн бусад үйл ажиллагаа, үйлчилгээг ил тод нээлттэй болгохыг зохицуулсан хууль, дүрэм, журманд цахим хуудсыг олонтаа дурдсан байдаг ч тодорхой зохицуулалт алга. Ийм цоорхойг бид нөхөж аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн мэдээллийн цахим сайтын загварыг санал болгож бүтэц, агуулгыг Загвар стандартад дэлгэрэнгүй тусгасан болно.

НОМЫН САН БОЛ ТӨСВИЙН МЭДЭЭЛЛИЙН ШИНЭ ОРЧИН, "БАРЬЖ ҮЗЭХ" БОЛОМЖ ЮМ

Төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангахад төрийн зүгээс мэдээллийн самбарт ихээхэн ач холбогдол өгдөг хэвээрээ байна. 2012 онд батлагдсан "Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам" бол үүний нэг жишээ юм. Урьд нь мэдээллийн самбар нь төрийн байгууллагын үйл ажиллагаа, хууль журмыг танилцуулж сурталчлах, иргэд, үйлчлүүлэгчдэд зар мэдээлэл хүргэхэд чухал үүрэгтэй байсан нь үнэн, гэхдээ одоо цагт, тэр тусмаа төсвийн мэдээллийг олон нийтэд хүргэх шаардлагыг хангахад больжээ. Үүнийг дээр дурьдсан журам батлагдсанаас хойш огт хэрэгжихгүй байгаа нь нотлон харууллаа.

Үүний оронд төсвийн мэдээллийн цахим сайтын үргэлжлэл болгож номын сан дахь төсвийн мэдээллийн булангийн загварыг бид санал болгож байна. Ингэснээр хотын захын дүүрэг, хөдөө орон нутаг, ер нь мэдээллийн технологи, Интернэтийг ашиглах боломжгүй хүмүүст төсвийн мэдээллийг нэгдүгээрт, цаасан дээр буулгасан хэлбэрээр, хоёрдугаарт, дэргэдээсээ авч байх болно.

Орчин үеийн номын сан гэдэг бол ном, хэвлэлийг хадгалж уншуулдаг танхим төдий биш иргэд, олон нийтийг төрөл бүрийн өргөн хүрээтэй мэдээллээр хангадаг үйлчилгээний төв болж шинэчлэгдэж байна. Тэр тусмаа манай номын сангууд бүгд төрийн өмч, татвар төлөгчдийн мөнгөөр үйл ажиллагаа явуулдаг учраас төрийн мэдээллийг олон нийтэд хүргэх үүрэгтэй гэж хэлж болно.

Төсвийн мэдээллийн буланг номын санд байгуулснаар,

- Иргэд тав тухтай үйлчлүүлэх боломж хангагдана. Ширээ сандалтай учраас сууж янз бүрийн, түүний дотор төсвийн мэдээллийг дэлгэж үзэх, нарийвчлан судлах, шаардлагатай бол тэмдэглэж авна. Хэрвээ зохих үйлчилгээ байгаа бол хувиалан авч болно.
- Төсвийн мэдээллийн булангийн материалууд тухайн номын санд бүртгэлтэй нэгж материал болж мэргэжлийн номын санчид зохих аргачлал, стандартын дагуу ангилж хадгалах ба шинэчлэх үүргийг хүлээнэ.
- Мэдээллийн буланг түшиглэж төр, захиргаа, төрийн бус байгууллагууд дангаараа буюу хамтран иргэд, олон нийт, татвар төлөгчдөд зориулж төсвийн баримт бичиг, үйл явцыг танилцуулах, лекц унших, уулзалт, хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах зэргээр төсвийн мэдээллийг ил тод нээлттэй болгож ажиллах асар өргөн боломж нээгдэнэ.

Энэ бол төсвийн мэдээллийн нэг цэгийн үйлчилгээ байх юм.

ОДОО ЗАГВАР СТАНДАРТЫГ БАРИМТАЛЖ ХЭВШИХ, ХЭВШҮҮЛЭХ НЬ ХАМГААС ЧУХАЛ

Төсвийн ил тод байдлыг нэг талаас орон нутгийн төр, захиргаа, төсвийн байгууллага, нөгөө талаас иргэд, олон нийт буюу тэдгээрийг төлөөлсөн төрийн бус байгууллагууд хамтран ажиллаж түншилсэн цагт хангаж чадна. Иймээс Ховд аймагт гэхэд төсвийн мэдээллийг цахим сайтад

оруулж, улмаар номын сангийн төсвийн буланг мэдээллээр хангах үүрэгтэй ажлын хэсэг ба хяналтын зөвлөл гэсэн хоёр бүтцийг байгууллаа.

Орон нутгийн санхүү, төрийн сангийн хэлтэс, төсвийн байгууллагын ажилтнууд цахим сайтад мэдээллээ байршуулах нь хамгийн хялбар бөгөөд хүртээмжтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Яагаад гэвэл тэд бүгд компьютер дээр ажиллаж төсвийн бүх мэдээллийг эхнээс нь дуустал цахим хэлбэрээр боловсруулж байгаа болохоор мэдээлэл үргэлж бэлэн, цаг хугацаа алдахгүй бөгөөд хэвлэх, хүргэх, түгээх шаардлагагүй. Орон нутагт төсвийн бүх байгууллага Интернэтэд холбогдож, наад зах нь Сангийн яамны санхүүгийн нэгдсэн системд нэвтэрч мэдээ тайлангаа явуулах боломжтой тул төсвийн мэдээллийн цахим сайт дахь тус тусын байгууллагын хуудсыг хариуцан хөтөлж мэдээллээ оруулдаг байх нь хамгийн оновчтой зохион байгуулалт юм. Чухам үүний тулд загвар сайтыг байгуулж төсвийн байгууллага, худалдан авалт тус бүрээр хуудас нээж дагаж мөрдөх загваруудыг ч гаргаж өгсөн. Үүнийг хэрэгжүүлбэл төсвийн цахим сайт үргэлж бүрэн, үргэлж шинэ байж чадна. Энэ нь төрийн байгууллага төсвийн мэдээллийн эх сурвалж байх ёстой зарчимтай нийцэж байна.

Гэхдээ загвар цахим сайтуудыг ажиллуулсан туршлагаас үзэхэд төсөв, санхүүгийн ажилтнууд сайтад мэдээлэл оруулах чадварыг хараахан эзэмшээгүй, эсвэл хэцүүд тооцож заавал мэргэжлийн хүнд даалгахыг эрмэлзэж байна. Улмаар өөрсдийн боловсруулж гаргадаг санхүүгийн тайлангийн хүснэгт, маягтуудыг Загвар стандартад нийцсэн эсэхийг харгалзахгүйгээр шууд хуулж өгөхөөс гадна электрон шуудан ашиглан файлаар илгээхийн оронд заавал цаасан дээр хэвлээд даргаараа батлуулж биетээр нь явуулж байна. Манайд цахим сүлжээ болон цахим гарын үсгийн баталгааны зарим асуудал эрх зүйн хувьд шийдэгдээгүй нь нөлөөлдөг.

Ийм нөхцөлд иргэд, олон нийтийн хяналт, оролцоо дахин шаардагдана. Төсөв, санхүүгийн ажилтнуудад амар хялбар бус, харин иргэдэд хэрэгтэй мэдээллийг Загвар стандартын дагуу ил тод болгохыг шаардах, тэгээд сайтад тавигдсан мэдээлэлд тулгуурлан орон нутгийн төсвийн төлөвлөгөө, хуваарилалт, зарцуулалтад хяналт тавих, мониторинг хийх зэргээр идэвхтэй ашиглаж оролцох нь ил тод байдлыг хэм хэмжээ, соёл болгож хэвшүүлэхэд шийдвэрлэх хүчин зүйл болж байна.

Загвар стандартын үндсэн баримт бичиг, түүнийг боловсруулах явцад цуглуулсан мэдээллийг <http://iltodtusuv.wordpress.com> сайтад байршуулсан болно. Мөн Ховд аймгийн khovdusuv.wordpress.com, Баянзүрх дүүргийн bzd2013.wordpress.com загвар сайтууд ажиллаж байна.